



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 11 өдөр

Дугаар 4657

Есөнбулаг сум

Төрийн болон орон нутгийн өмчийн
эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын ажлыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 4, 72 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 238 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2026 оны 143 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах журам, "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн тооллогын маягт, хүснэгтийг ашиглах заавар"- ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг орон нутагт удирдан зохион байгуулах аймгийн төв комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга :	М. Алтангэрэл	(Аймгийн Засаг даргын орлогч)
Комиссын орлогч дарга:	Л. Хаш-Эрдэнэ	(Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)
Гишүүд:	Н. Эрдэнэ-Очир	(Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	Л. Ганхуяг	(Орон нутгийн өмчийн газрын дарга)
	Г. Чүлтэмжамц	(Улсын бүртгэлийн хэлтсийн дарга)
	Ж. Мянганбаяр	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	О. Баатарчулуун	(Эрүүл мэндийн газрын дарга)
	Д. Энхцэцэг	(Боловсролын газрын дарга)
	С.Цагаанбаатар	(Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга)
	С. Гантулга	(Говь-Алтай аймаг дахь Автотээврийн төвийн дарга)
	Б.Золзаяа	(Орон нутгийн өмчийн газрын өмчийн ашиглалт, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн)
	О.Лхам	(Орон нутгийн өмчийн газрын өмчийн хяналт, шалгалт, бүртгэл, мэдээлэл хариуцсан

D:zahiramjZax ZD 2026

8000080436

Ц.Эрдэмбилэг

мэргэжилтэн)

(Орон нутгийн өмчийн газрын
өмчийн удирдлага, төлөөлөл
хариуцсан мэргэжилтэн)

(Сумдын Засаг дарга нар)

Нарийн бичгийн дарга: О.Даваажаргал

(Орон нутгийн өмчийн газрын
өмчийн хяналт, шалгалт,
бүртгэл ашиглалт хариуцсан
ахлах мэргэжилтэн)

2.Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг шийдвэр, журам, аргачлал, заавар маягтын дагуу хугацаанд нь чанартай зохион байгуулж, 2026 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн дотор аймгийн нэгдсэн дүнг танилцуулахыг комиссын дарга (М.Алтангэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ